

## **ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

### **I.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй” гэж заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурал 2001 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталж, мөн оныхоо 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Тус хуулийг 2011 онд шинэчлэн найруулсан бөгөөд үүнээс хойш 2011, 2012, 2014-2017, 2021-2024 онуудад уг хуульд нийт 20 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэ хууль нь 7 бүлэг, 34 зүйлээс бүрддэг. Тус хуулиар хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний хөдөлмөрийн эрх, эрх чөлөөг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулсан юм. Гэсэн хэдий ч энэхүү хуулиар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл байдал үүссээр байна. Гэсэн хэдий ч энэхүү хуулиар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл байдал үүссээр байна. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр салбар дундын бодлогын уялдаа холбоог хангагдаагүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар гүйцэтгүүлэхээр заасан нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг төрийн болон хувийн биржээр гүйцэтгүүлдэг олон улсын жишиг зохицуулалттай нийцээгүй, хуулийн хүрээнд үзүүлж буй дэмжлэг, туслалцаа нь харилцан уялдаа холбоо багатай цогц биш тул үр ашигтай, тогтвортой хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэлтийг дэмжихэд хязгаарлагдмал шинжтэй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр нь гадаад ажилтан авч ажиллуулсны төлбөрөөс хамааралтай, хүртээмж багатай зэргийг дурдаж болохоор байна.

Мөн бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, шинэлэг гарааны бизнес эрхлэгчийг дэмжих замаар албан бус хөдөлмөр ба бизнес эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэх, улмаар жижиг, дунд үйлдвэр болгон үе шаттай хөгжүүлэх буюу жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай үйл ажиллагаагаа нягт уялдуулах эрх зүйн орчин үгүйлэгдэж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг хөдөлмөрийн насны болон хөдөлмөрийн чадвартай иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан зарим арга хэмжээ, үйлчилгээнд заавал хамрагдах нөхцөлтэйгээр халамжийн зарим үйлчилгээг үзүүлэх “халамжаас хөдөлмөрт шилжүүлэх” хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Монгол Улс Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 1948 оны 31 дүгээр чуулганаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай” 88 дугаар конвенци, 1997 оны 85 дугаар чуулганаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай” 181 дүгээр конвенцид 2015 онд тус тус нэгдэн орсон бөгөөд эдгээр конвенцид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг нийцүүлэх шаардлагатай байна.

Ийнхүү Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь нийт 7 бүлэг, 45 зүйлтэй. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан танилцуулья. Үүнд:

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Хуулийн төслийн нийтлэг үндэслэлд хуулийн зорилгыг “хүн амын зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлээс сэргийлэх, ажил хайгч, зорилтот бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, зохион байгуулалт, санхүүжилт, тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулахад оршино” гэж өөрчлөн томъёоллоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжид боловсролын суурь харилцааг зохицуулах Боловсролын ерөнхий хууль, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлж хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх харилцааг зохицуулах Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль хамрагдахаар нэмж оруулсан.

Хуулийн төсөлд “байнгын ажил”, “түр ажил”, “гарааны бизнес”, “кейс менежмент”, “хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого”, “хөдөлмөр эрхлэлтийн байгууллага” зэрэг шинэ нэр томъёоны тодорхойлолтыг оруулж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын шинэчлэлийн хэрэгцээ, олон улсын болон бусад улс орны жишигт нийцүүлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг эдийн засаг, нийгмийн салбаруудад хамааралтай байхаар өргөжүүлж байгаатай холбогдуулан уг үйл ажиллагаанд баримтлах ерөнхий зарчмуудыг тодорхойлж тусгасан. Тухайлбал хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зохистой хөдөлмөрийг нэмэгдүүлэх, ногоон, цахим шилжилт, халамжаас хөдөлмөрт, идэвхтэй насжилтыг дэмжих, хувь хүнд чиглэсэн кейс менежментэд тулгуурлах, тогтвортой хөдөлмөр эрхлэлтэл чиглэсэн ур чадварын хөгжил, насан туршийн суралцахуйг дэмжих зарчмыг баримтална.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хөдөлмөрийн салбарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар явуулж байгаа өнөөгийн үйл ажиллагааг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, зохион байгуулалт” гэсэн бүлгийн хүрээнд бодлогын практик хэрэгцээ шаардлага, дотоодын хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, олон улсын жишигт нийцүүлж шинэчилж тусгав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь ажилгүй иргэн, ажил хайгч, ажил олгогчийн хүсэлт хэрэгцээнд тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ болон арга хэмжээ гэсэн хоёр төрөлтэй байна.

Хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байнгын шинж чанартай буюу тогтмол хэрэгжүүлэх үйлчилгээ, арга хэмжээг ангилж өгөх, шаардлагатай тохиолдолд үйлчилгээ, арга хэмжээг биечлэн, цахимаар, зайнаас, эсхүл холимог хэлбэрээр үзүүлж болохтой холбоотой зохицуулалтыг шинээр тусгасан. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэмэлт, тусгайлсан болон цогц дэмжлэг шаардлагатай зорилтот бүлгийн иргэнийг тодорхойлж, эдгээр иргэнийг кейс менежментийн аргачлалыг ашиглан дэмжихтэй холбоотой зохицуулалтыг нэмсэн.

Энэ бүлгийг дотор нь хоёр дэд бүлэгт хуваасан.

### **Нэгдүгээр дэд бүлэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээг “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ” гэж өөрчлөн “ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах”, “ажилд зуучлах”, “ажилгүйдлийн тэтгэмж олгох”, “нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах”, “бусад үйлчилгээ” гэсэн байсныг дараах байдлаар төрөлжүүлж, үйлчилгээний зохион байгуулалттай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгаж өгсөн. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах;
2. Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах;
3. Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөгжил, төлөвлөлтийн зөвлөгөө өгөх;
4. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох үйлчилгээ үзүүлэх;
5. Ажилд зуучлах.

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үйлчилгээ нь иргэн, ажил олгогчид хэрэгцээтэй мэдээллийн дэмжлэг болохын сацуу нотолгоонд суурилсан бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагааны гол хэрэглэгдэхүүн болох юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд шинэ үйлчилгээ болж нэмэгдэж байгаа “хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах” үйлчилгээ нь олон улсад жишиг болсон мэргэжлийн үйлчилгээ ба ажил хайгч иргэний хөдөлмөр эрхлэх чадварын нөхцөл байдал, боломжийг үнэлэн тодорхойлж, тохиромжтой дэмжлэгийг үзүүлэхэд чиглэх юм. Мөн түүнчлэн уг үйлчилгээг үзүүлэх мэргэжилтэнд тавигдах шаардлага, үйлчилгээний зардлын дэмжлэг, зохион байгуулалттай холбоотой харилцааг тодорхой заасан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөгжил, төлөвлөлтийн зөвлөгөө өгөх үйлчилгээг ажил мэргэжлийн талаарх мэдээллээр хангах, тохирох ажил мэргэжлийн оношилгоо хийж чиглүүлэх, ажил мэргэжлийн ахиц дэвшил, өөрчлөлтийн чиглэлийг тодорхойлж, түүнд хүрэх зорилго, алхмуудыг үе шаттайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцыг удирдан зохицуулахад зөвлөн туслах үйлчилгээ байхаар өргөжүүлсэн. Энэхүү үйлчилгээг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад үзүүлэх чиг үүргийг боловсролын, насанд хүрэгчдэд үзүүлэх чиг үүргийг хөдөлмөрийн салбар хариуцах зохицуулалтыг тодорхой зааж өгсөн.

Хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох үйлчилгээ нь ажлын байрны зөөлөн болон цахим ур чадвар, хөдөлмөрийн харилцааны мэдлэг олгох, ажлын байранд дасан зохицох, өөрийгөө бэлтгэх, ажил хайх арга барилд сургах зорилготой зөвлөгөө, мэдээлэл болон сургалтын дэмжлэг байна.

### **Хоёрдугаар дэд бүлэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь “хөдөлмөрт бэлтгэх”, “хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах”, “малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих”, “ажил олгогчийг дэмжих”, “нийтийг хамарсан ажил зохион байгуулах”, “ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэсэн ихэвчлэн ямар нэг зорилтот бүлгийг дэмжихтэй холбоотой байсан.

Хуулийн төсөлд өмнө байсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэлбэр, агуулгыг шинэчлэхийн сацуу шинэ төрлийн арга хэмжээг нэмж дараах 8 төрөлтэйгээр хэрэгжүүлдэг байхаар зохицуулсан. Үүнд:

1. Мэргэжлийн сургалт зохион байгуулах;
2. Дагалднаар ажиллахыг дэмжих;
3. Дагалднаар суралцахыг дэмжих;
4. Бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх;
5. Аж ахуй эрхлэхийг дэмжих;
6. Ажил олгогчид хөдөлмөрийн харилцааны дэмжлэг үзүүлэх;
7. Хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
8. Олон нийтийн ажил зохион байгуулах.

Хуулийн төсөлд шинээр нэвтрүүлэхээр тусгасан дагалднаар ажиллах, дагалднаар суралцах арга хэмжээ нь илүү уян хатан, хүртээмжтэй байх зохицуулалтаар зорилтот бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэж байгаа тул тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байх юм.

Хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулах хүсэлтэй, хэрэгцээтэй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэгийн арга хэмжээг цогцоор нь үзүүлдэг байхаар арга хэмжээг шинэчилсэн. Тухайлбал “бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх” арга хэмжээгээр дамжуулан хувиараа хөдөлмөр эрхлэгч, гарааны бизнес болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бизнес эрхлэх бэлэн байдал, ур чадварын

үнэлгээнд хамруулж, сургалтанд хамруулах, “аж ахуй эрхлэхийг дэмжих” арга хэмжээний хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эхлүүлэх, өсгөх, төлөвшүүлэх, бараа бүтээгдэхүүн хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэх, борлуулах, сүлжээ үүсгэх, богино хугацааны эргэлтийн хөрөнгө, түрээсийн дэмжлэг олгох зорилготой цогц дэмжлэг болох санхүүгийн дэмжлэг болон жижиг зээл олгох зохицуулалтыг тусгасан.

Ажил олгогчид хөдөлмөрийн харилцааны дэмжлэг үзүүлэх зорилготой хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөгөө өгөх, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сургалтад хамруулахтай холбоотой арга хэмжээг хуулийн төсөлд тусгасан.

Ажилгүй хүн, ажил хайгч, зорилтот бүлгийн иргэнд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнээс гадна хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн, хэрэгцээнд тулгуурласан зарим арга хэмжээг хэрэгжүүлж болохоор хуульчилсан. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, малчин, байнгын асаргаатай хүн асарч байгаа хөдөлмөрийн насны хүн, урт хугацаанд ажилгүй байгаа, ажлын туршлага нь тасалдсан эмэгтэйчүүд, залуучууд зэрэг хүн амын бүлгийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг тодорхойлж өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэг төрөл “олон нийтийн ажил зохион байгуулах” юм. Энэ нь орон нутгийн төрийн байгууллага, ашгийн бус байгууллагууд хамтран гэрээ байгуулж, тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардагдах байнгын, урт хугацааны болон байнгын бус, богино хугацааны цалин хөлстэй ажилд иргэдийг хамруулах арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой арга хэмжээ юм. Хуулийн төсөлд олон нийтийн ажил зохион байгуулах гэрээнд тусгах зохицуулалтыг нарийвчлан тусгаж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хэрэгжилттэй уялдаатай байхыг тусгасан.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦОО**

“Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээлэл” гэсэн бүлгийн нэрийг “Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоо” гэж өргөтгөн нэрлэж, уг тогтолцооны зорилго, үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцооны бүтэц, мэдээллийн нэгдсэн сан, түүний зориулалт, мэдээллийн тогтолцоог хариуцах байгууллагын талаар шинэчлэн тодорхойлсон. Өөрөөр хэлбэл өнөөгийн мэдээллийн тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн зориулалтаар түлхүү ашиглагдаж, ажилладаг байсныг хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлал, өөрчлөлт, чиг хандлагыг ажиглах, дүн шинжилгээ хийх зэрэг өргөн хүрээнд ашигладаг байхаар өргөтгөж, шинэ зохицуулалтыг тусгасан.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцооны зорилго нь хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх бодитой, хүртээмжтэй мэдээллээр бодлого боловсруулагч, ажил олгогч, иргэн, боловсрол, сургалтын байгууллага, мэргэжлийн байгууллагыг түргэн шуурхай

хангах явдал юм. Энэхүү тогтолцоо нь үндэсний статистик, боловсрол, нийгмийн даатгал, нийгмийн халамж, улсын бүртгэл зэрэг бусад төрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, уялдаа холбоотой ажиллахаас гадна хувийн хэвшлийн ижил төстэй мэдээллийн эх үүсвэртэй хамтран ажиллаж болох юм.

Хуулийн төсөлд мэдээллийн тогтолцоог хариуцах байгууллагын чиг үүргийг ангилан тодорхойлсон. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн нэгдсэн сан, сүлжээний үйл ажиллагааны аюулгүй байдал, хамгаалалтын журам, стандартыг тогтоож хяналт тавих, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах чиг үүргийг хариуцна. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, нэгтгэх, тайлан мэдээлэл бэлтгэх, түгээх, техник хангамжийг хөгжүүлэх зэрэг чиг үүргийг хариуцаж, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх чиг үүргийг хөдөлмөрийн судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хариуцах талаар зааж өгсөн.

Мөн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцооны программ хангамжийг хөгжүүлэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болохтой холбоотой зохицуулалтыг тусгалаа.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэрт нэмэлтээр сангийн өмнөх оны чөлөөт үлдэгдэл, ахмад настныг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийн хөрөнгийг хамааруулахаар зохицуулав.

Хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төлөвлөлттэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тодорхойллоо.

Сангийн төлөвлөлтийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан бодлогын зорилго, үр дүнтэй уялдсан, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд суурилсан үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн аргачлалд тулгуурлан хийх ба төсвийн төлөвлөлтийг орон нутгийн түвшнээс эхлэн үе шаттайгаар хийх асуудлыг тусгасан. Үүнд:

- Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага харьяалах нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, онцлог, хэрэгцээнд тулгуурласан төсвийн төслийн саналыг бэлтгэж, өмнөх оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багтаан хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага аймаг, дүүргийн саналыг хүлээн авч, үндэслэл, бодит хэрэгцээг хянаж нэгтгэсэн төсвийн саналыг бэлтгэж, өмнөх оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

- Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн жилийн төсвийн төслийн саналыг Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх талаар хуульчилсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын төрөл, хэмжээ, олгох нөхцөл, шаардлагыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталдаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой харилцааг дараах байдлаар багцлан харуулж байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ болон Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс зорилтот бүлгийн иргэн, хүн амын бүлгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцооны үйл ажиллагаа зохион байгуулах;
- Хөдөлмөрийн салбарын ажилтны чадавх бэхжүүлэх сургалт, давтан сургалт зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох;
- Хөдөлмөрийн салбарын судалгаа, шинжилгээний ажил хийх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих.

Хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын төсөвтэй холбоотой зохицуулалтын хүрээнд санд улсын төсвөөс хөрөнгө хуваарилахдаа хөгжлийн бодлогын зорилт, сангийн өмнөх оны орлогын гүйцэтгэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлт зэргийг харгалзан үзэх талаар өргөтгөж өгсөн.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсвийг хуваарийг батлах, батлагдсан төсвийг хуваарилах болон сангийн орлого, зарлагын тайлангийн цаглабарыг тодорхойлон тусгасан. Төсвийн хуваарилалтад хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас боловсруулж баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг баримтлахтай холбоотой зохицуулалтыг нэмсэн.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО**

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоог энэ хуулийн 30.1-д заасан Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

төв байгууллага, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан, хөдөлмөрийн судалгаа, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллага, иргэнээс бүрдүүлэхээр шинэчлэн зохицуулав.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл байсныг улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн бодлогын талаар зөвлөлдөх чиг үүрэг бүхий Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл болгож, зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллага, ажилтан, ажил олгогч, эрдэмтэн судлаачийн төлөөллөөс бүрдэхээр бүрэлдэхүүнийг өргөжүүлсэн. Төрийн байгууллагын төлөөллийг илүү олон салбараас бүрдүүлэхээр өөрчилж, эдийн засгийн хөгжил, боловсрол, төсөв санхүү, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл байхаар тусгалаа. Ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагаас тус бүр 5, эрдэмтэн, судлаачийн төлөөлөл нь эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн 3 төлөөллөөс бүрдэнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, стратеги, үйл ажиллагааны төслийг хэлэлцэн санал, зөвлөмж өгөх, зорилтот бүлгийн иргэн, хүн амын бүлгийн онцлог, хэрэгцээнд нийцсэн төсөл, хөтөлбөрийг хэлэлцэн батлах, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, боловсронгуй болгох болон хэрэгжилтийн үнэлгээний тайлантай танилцаж санал, зөвлөмж өгөхтэй холбоотой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, судалгаа, шинжилгээ хийж мэдээллээр хангах ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн тогтолцооны байгууллагуудын хариуцах чиг үүргийг ангилан төрөлжүүлж, нарийвчлан тодорхойлж өгсөн.

Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого, стратеги тодорхойлох, бодлогын уялдаа, хэрэгжилтийг хангуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэрэгжүүлэх чиг үүргийг дараах байдлаар багцлан зохицууллаа. Үүнд:

- эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- салбарын болон салбар дундын бодлогын уялдааг хангах, зохицуулалт хийх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;
- хөдөлмөрийн зах зээлийн их өгөгдлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөгжүүлэх;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн эх үүсвэр, төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт хийх, зарцуулалтад хяналт тавих;

- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;
- энэ хуулиар эрх олгогдсон журам, стандарт, аргачлал, маягтыг мөрдүүлэх;
- гадаад улстай хөдөлмөрийн асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, гэрээ конвенцод нэгдэх асуудлыг судлах, шийдвэрлүүлэх;
- хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Аймаг, дүүрэг, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллагыг бодлогын хэрэгжилтийн удирдамж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийн хүрээнд бусад төрийн байгууллага, нийгмийн түншүүд, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хувийн болон мэргэжлийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах;
- Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг батлах, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтнуудын бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбоотой чиг үүргийг шинээр тусгаж өргөжүүлсэн.

Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах судалгаа, шинжилгээ, салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын статус, хариуцах чиг үүргийг тодорхой болгож, холбогдох зохицуулалтуудыг нэмсэн. Тус байгууллага нь хөдөлмөрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахаас гадна дараах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, бодлогын санал зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Макро эдийн засгийн үзүүлэлт, хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөлөл, хамаарлын судалгаа, шинжилгээ;
- Эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, ур чадварын түвшнээрх ажиллах хүчний богино, дунд, урт хугацааны судалгаа, хэтийн тооцоолол, таамаглал, шинжилгээ;
- Хөдөлмөрийн зах зээлийн их өгөгдлийн мэдээллийн дүн шинжилгээ;
- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний судалгаа, шинжилгээ;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөөний судалгаа, шинжилгээ;
- Хөдөлмөрийн асуудлаарх бодлого, стратегийн санал, зөвлөмж байна.

Орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтны үүрэг, оролцоо чухал ач холбогдолтой тул тэдний хариуцах чиг үүргийг нарийвчлан тусгалаа. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, сурталчлах, хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах;
- Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд ажилгүй хүн, ажил хайгч, ажлын байрны захиалгын бүртгэл, судалгаа хийх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг шуурхай, бүрэн, үнэн зөв оруулах, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;
- Нутгийн удирдлагын байгууллага, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага, төрийн бус байгууллага, боловсрол, сургалтын байгууллагатай орон нутгийн хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
- Ажил олгогчтой хамтран ажиллах хүчний эрэлт, хэрэгцээг тодорхойлох, сул ажлын байрыг нөхөх, захиалгат мэргэжлийн сургалт зохион байгуулах, зорилтот бүлгийн иргэнийг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл солилцох чиглэлээр дэмжиж ажиллах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, иргэний бүртгэл зэрэг байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангуулах;
- Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтнуудын мэргэжил, ур чадварын тасралтгүй хөгжил, цахим хэрэгсэл, кейс менежмент, ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллагатай хамтран ажиллах чадавхийг сайжруулах;
- Харьяалах нутаг дэвсгэрийн нөхцөл байдал, хэрэгцээнд тулгуурласан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн саналыг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлэх, төсвийн зарцуулалтыг зориулалтын дагуу үр дүнтэй зохион байгуулах
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг болно.

Хуулийн төсөлд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр хариуцах бүрэн эрх, үүргийг тодорхойлсон.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөл хөтөлбөр болон шаардлагатай төсвийн саналыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн төсөвт тусган батлах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих, энэ чиглэлээр нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, байгууллагын үйл ажиллагаа болон ажил олгогч, хөрөнгө оруулагч, бусад мэргэжлийн байгууллагын уялдаа холбоог хангаж, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Мөн алслагдсан болон хөдөө, орон нутгийн иргэн, зорилтот бүлгийн иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг хүртээмжтэй хүргэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн ажилтны ажлын гүйцэтгэл, тайланг хянаж, үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах талаарх санал, зөвлөмж холбогдох байгууллагад хүргүүлэх талаар зохицууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын удирдлагын тогтолцоо нь аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтныг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөлдөг байхаар өөрчлөн найруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцооны бүлэгт “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн байгууллага”, “нийгмийн түншүүд”-ийн чиг үүргийн талаарх тусгайлсан зүйлийг тусгаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой нийгмийн түншлэл, төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаарх зохицуулалтыг тодорхой болголоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх мэргэжлийн бусад төрийн, төрийн бус байгууллага болон иргэн байна.

Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан нь шаардлага хангасан, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоонд бүртгүүлсэн байгууллага, иргэнтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг гэрээ байгуулж, гүйцэтгүүлж болохыг хуульчилсан. Мөн гэрээлэн гүйцэтгүүлэх харилцаанд баримтлах зарчим, үүрэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг тусгаж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгууллага, иргэнд тавигдах шаардлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, тэднийг бүртгэх, гэрээ байгуулах, санхүүжилт олгох журмыг батлахаар зохицууллаа.

Одоогийн мөрдөгдөж байгаа хуульд байгаа “Хөдөлмөрийн бирж” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага” гэж өөрчлөн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг үзүүлэх, энэхүү үйлчилгээг хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар төрөлжүүлэн хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх, бусад хууль тогтоомж, гэрээнд заасан бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга

хэмжээг хэрэгжүүлж болохоор тусгаж хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хязгаарлагдмал оролцоотой байсан ажилтан, ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нийгмийн түншлэгч байгууллагын үүрэг, оролцоог тодорхой болгож, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр шинэчлэн найрууллаа. Үүнд:

- Ажилтан, ажил олгогчийн ур чадвар, бүтээмжийн өсөлтийг дэмжих, ажлын байр бий болгох, хадгалах, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх, зохистой хөдөлмөрийг хангах зэргээр хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагаанд оролцож, хамтран ажиллах;
- Ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн мэдээлэл солилцох, ур чадварын хэрэгцээг тодорхойлох, эрэлтэд нийцсэн сургалт хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтантай хамтран орон нутагт ажилгүйдлийг бууруулах, зорилтот бүлгийн иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ур чадварын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулах, ур чадвар олгох, давтан сургах, хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах, сургалтын орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангахад дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийн болон боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллах;
- Хөдөлмөрийн зах зээлийн тооцоолол, таамаглалын судалгаанд хамрагдах, холбогдох мэргэжлийн байгууллагыг ажиллах хүч, ур чадварын эрэлт, хомсдол, ажлын байрны чиг хандлагын талаарх мэдээллээр хангах
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцож, үйл ажиллагааны чанар, үр дүн, бодлогын үр нөлөөг үнэлж, дүгнэхэд оролцох болно.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцооны иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаан дахь хамтын ажиллагааг тодорхойлж, оролцоог нэмэгдүүлэх, үүрэгжүүлэх байдлаар хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтантай идэвхтэй хамтран ажиллахаар өөрчлөн найруулсан.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ**

Хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналттай холбоотой зохицуулалтыг зургаадугаар бүлэгт нэгтгэж, хяналтын үйл ажиллагааны хамрах хүрээ, хяналт тавих байгууллага, албан тушаалтан, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийн талаар тусгалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтын үйл ажиллагаа дараах хяналтаас бүрдэнэ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зохион байгуулалт, чанар, хүртээмжтэй байдлын хяналт
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зарцуулалт, гүйцэтгэлийн хяналт
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн болон мэргэжлийн бусад байгууллага, иргэний гэрээний гүйцэтгэлийн хяналт;
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцооны үйл ажиллагаа, аюулгүй байдал, ашиглалт, хүртээмжийн хяналт;
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой бусад хяналт байна.

Одоогийн мөрдөгдөж байгаа хуулинд заасан хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг өргөжүүлж, олон нийтийн хяналтыг олон нийтийн байгууллага тавихаар шинэчилсэн.

Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ. Мөн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр хариуцах чиг үүргийг дараах байдлаар нарийвчлан тусгалаа.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийн бүх төрлийн хяналтын үр дүнг харьцуулах боломжтой, өгөгдөл, мэдээллийн нийцтэй байдлыг хангах нэгдсэн аргачлал, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлах;
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих үйл ажиллагааны хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэлийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоогоор дамжуулан хянах боломжийг бүрдүүлсэн байх;
- Хяналтын ажлын үр дүнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах төлөвлөгөө, гүйцэтгэлийн түвшинг нэмэгдүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж хэрэгжилтийг хангуулах;
- Хяналтын ажлын товч танилцуулга, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, гол үр дүнг багтаасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг болно.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

Хуулийн төслийн долоодугаар бүлэг “Бусад зүйл”-д хууль тогтоомж зөрчигчөд хүлээлгэх хариуцлагын хүрээнд “буруутай этгээд хохирлыг нөхөн төлөх”-тэй холбоотой зохицуулалтаар өргөжүүлж, “Хуулийн хэрэгжилтийн шилжилтийн заалтууд” гэсэн шинэ зүйлийг нэмлээ.

Хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор Засгийн газар хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах холбогдох журам, зохицуулалтыг батлах,

нэг жилийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоо болон кейс менежментийн аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлэх талаар хуулийн төсөлд тусгалаа.

## **II. Дагах хуулиудын төслийн талаар**

Хуулийн төсөлтэй холбогдуулан 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хүчингүй болсонд тооцож тухай болон доор дурдсан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсрууллаа.

### **1) Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Энэ хуулийн 32 дугаар зүйлд “Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ” гэсэн шинэ заалт нэмэх төсөл боловсруулсан.

### **2) Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Энэ хуулийн 13.7 дахь хэсгийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настанд зарцуулах хөрөнгө нь тус сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна” гэж өөрчлөн найруулах төсөл боловсруулсан.

### **3) Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан гарааны бизнес эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн аж ахуй эрхлэх үйл ажиллагааг үе шаттайгаар дэмжиж хөгжүүлэх шаардлагыг үндэслэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд дараах хэсэг, заалт нэмэхээр зохицууллаа:

“8.1.11.гарааны бизнес эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагааны өсөлт, хөгжлийн дараагийн шатны санхүүгийн болон зах зээлийн дэмжлэг үзүүлэх;”

“11.11<sup>1</sup>.Сангаас дараах нөхцлийн аль нэгийг хангасан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хөнгөлөлттэй зээлийг эхний ээлжинд олгоно:

11.11<sup>1</sup>.1.жижиг, дунд үйлдвэрийн нийт ажиллагсдын 50-иас доошгүй хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг;

11.11<sup>1</sup>.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авч хуваарийн дагуу хугацаандаа төлсөн, аж ахуйн эрхлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ажлын байр бий болгох хүсэлт гаргасан;

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.2.гарааны бизнес эрхлэгч, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг батлах;”

“18.1.1.тухайн шатны жил бүрийн төсөвт гарааны бизнес, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг дэмжих болон хөгжүүлэх экосистем бүрдүүлэх зориулалтаар хөрөнгө тусгаж батлах;”

“18.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гарааны бизнес, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг дэмжих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, бизнесийг дэмжих экосистем бүрдүүлэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.”

#### **4) Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилдсэн найруулгын төсөлд шинээр тусгасан “дагалдан ажиллахыг дэмжих”, “дагалдан суралцахыг дэмжих” арга хэмжээ болон зорилтот бүлгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн уялдааг хангах зорилгоор дараах заалтыг нэмэх төсөл боловсрууллаа:

“11.1.1<sup>1</sup>.залуучуудыг дагалднаар ажиллах, дагалднаар суралцахад дэмжлэг үзүүлэх, хяналт, үнэлгээ хийх ажлыг хөдөлмөрийн, боловсролын болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, ажил олгогчийн төлөөллийн байгууллага хамтран хэрэгжүүлэх;

11.1.1<sup>2</sup>.ажил хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудад зориулсан арга хэмжээг хөдөлмөрийн, боловсролын болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн төлөөллийн байгууллага хамтран хэрэгжүүлэх;”

Хуулийн 20.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.2.6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан зорилтот бүлэгт хамаарах залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамруулахад хөдөлмөрийн асуудал хариуцсан орон нутгийн

байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагатай хамтран ажиллах;”

**5) Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Энэ хуулийн 10.12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмэх:

“4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Энэ хуулийн 10.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэнээс шууд болон шууд бус хэлбэрээр төлбөр авсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**6) Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр орон нутгийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үүрэг, оролцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн дараах зохицуулалтыг хуулинд нэмэлтээр тусгахаар боловсрууллаа:

“58.1.5<sup>1</sup>.орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, ажилгүй иргэн, ажил хайгч, зорилтот бүлгийн иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулах;”

“59.1.19<sup>1</sup>.Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх;”

“60.1.10<sup>1</sup>.орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, салбар дундын бодлого, зохицуулалтаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн түншлэлийг дэмжих;”

“61.1.9<sup>1</sup>.орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, ажилгүй иргэн, ажил хайгч, зорилтот бүлгийн иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах ажлыг зохион байгуулах;”

“62.1.10<sup>1</sup>. орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх, салбар дундын бодлого, зохицуулалтаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн түншлэлийг дэмжих;”

“63.1.10<sup>1</sup>.ажилгүйдлийг бууруулах, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр нийслэл, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Тамгын газрын холбогдох хэлтэс, албаны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх;”

Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.5.7.хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх;”

## **7) Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

“8.3.1<sup>1</sup>. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах зохицуулалт;”

## **8) Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Ажил хайгч, ажилгүй иргэний мэргэжлийн сургалтанд хамрагдах арга хэмжээний зардалтай холбоотой холбогдох хуулиудын уялдааг хангах шаардлагаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд доор дурьдсан зүйл, хэсэг, заалтыг нэмэлтээр оруулах:

“14 дүгээр зүйл.Мэргэжлийн сургалтын зардал олгох.”

11.1.Мэргэжлийн сургалтыг дараах хөтөлбөрийн дагуу зохион байгуулна:

“14.1.Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд мэргэжлийн сургалтанд хамрагдсан тохиолдолд ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтын зардлыг санхүүжүүлнэ.”

“2.2.3.мэргэжлийн сургалтын зардал олгох.”

**9) Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах, кейс менежментэд суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг нийгмийн халамж зэрэг бусад нийгмийн суурь үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуульд дараах зүйлийг нэмэх төслийг боловсрууллаа.

“22<sup>1</sup> дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа

22<sup>1</sup>.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зорилго нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа, үйлчилгээнд хамрагдаж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч ажилгүй, ажил хийх боломжтой иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх болон аж ахуй эрхлэхэд туслан дэмжих, амьдралын чанарыг сайжруулахад оршино.

22<sup>1</sup>.2.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа, үйлчилгээнд хамрагдаж байгаа ажилгүй иргэний кейс менежментэд суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь боловсрол, эрүүл мэнд зэрэг бусад салбарын бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан, цогц дэмжлэг байна.

**10)Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Захиргааны статистик мэдээллийн уян хатан байдлыг хангах хэрэгцээ, шаардлагад үндэслэн Статистикийн тухай хуулийн 12.1.4 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулах:

“12.1.4.захиргааны статистикийн мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэлтэй давхардуулахгүй байх, арга зүйн нэгдмэл байдлыг хангах зорилгоор хянах, захиргааны статистикийн мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөх, санал өгөх, мэдээллийн хамралт, үнэн зөв байдалд үнэлэлт өгөх.”

**11)Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай**

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах нь улсын хөгжлийн бодлогын төвд байх, салбар дундын бодлого, зохицуулалтаар хэрэгжүүлэх шаардлагатай тул хуульд дараах заалтыг нэмэхээр тусгалаа.

“5.1.18.хөгжлийн бодлогын үндэс нь хөдөлмөр эрхлэлт байх.”

**12)Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Дараах заалтыг нэмэх:

“28.1.17.Шинээр ажилд орсон ажилтан, дагалднаар суралцагч, дагалднаар ажиллагчийг аюул, эрсдэлгүй ажиллах, дадалтай болгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;”

Хуулийн 17.2.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах:

“17.2.1.Шинээр ажилд орсон ажилтан, дагалднаар суралцагч, дагалднаар ажиллагчийн сургалт;”

**13)Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Дараах хэсэг нэмэх:

“2.4<sup>1</sup>.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1.1-д заасан бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь энэ хуулийн 4.1.10-т заасан хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг батлаагүй тохиолдолд хөдөлмөрийн харилцааны холбогдох асуудлыг ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд бүрэн тусгах үүрэг хүлээнэ.”

“145.5<sup>1</sup>.Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 145.4-т зааснаар ахмад настныг ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлнө.”

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**